

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баян-Өлгий аймгийн Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/55/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Х.Еркебулан Утас: 92921881 Цахим хаяг: erkebulankh@ audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
Байхгүй .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

**БУЯНТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ К.ХАВАЛХАС ТАНАА**

᠒᠐22.᠐᠑.25 № 179  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн-Дүгнэлт

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн-Дүгнэлт

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>55,024,545.38</u></b>	<b><u>59,352,889.38</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	7,460,464.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,460,464.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	47,564,081.38	59,352,889.38
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	100,190.00	495,990.00
35130	Эм боох материал	100,190.00	495,990.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	37,297,891.38	49,870,899.38
35410	Бичиг хэргийн материал	4,097,560.00	1,689,570.00
35420	Аж ахуйн материал	33,045,686.38	38,501,536.38
35460	Хүнсний материал	142,065.00	9,667,213.00
35470	Бусад хангамжийн материал	12,580.00	12,580.00
35600	Мал амьтад	10,166,000.00	8,986,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>799,685,367.37</u></b>	<b><u>788,647,500.96</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	799,685,367.37	788,647,500.96
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	756,285,367.37	740,389,500.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	804,283,848.88	804,283,848.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(167,005,405.10)	(206,677,398.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141,098,467.35	173,607,544.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(111,130,626.26)	(120,582,273.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	118,218,998.92	118,538,542.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(60,586,189.21)	(62,876,086.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,622,200.00	20,482,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,745,543.21)	(17,245,543.17)
39217	Ном	27,529,616.00	30,858,665.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	43,400,000.00	48,258,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(750,000.00)

39303	Бусад биет бус хөрөнгө	43,400,000.00	48,258,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>854,709,912.75</b>	<b>848,000,390.34</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,371,996.00</b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15,371,996.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	15,371,996.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	15,371,996.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>839,337,916.75</b>	<b>848,000,390.34</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	839,337,916.75	848,000,390.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	679,906,375.91	679,906,375.91
51101	Өмч: - төрийн	679,906,375.91	679,906,375.91
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(436,111,763.50)	(427,449,289.91)
51210	Өмнөх үеийн үр дүн	(401,150,264.78)	(436,111,763.50)
51220	Тайлант үеийн үр дүн	(34,961,498.72)	8,662,473.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	595,543,304.34	595,543,304.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>854,709,912.75</b>	<b>848,000,390.34</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,256,599,108.46</b>	<b>1,290,136,978.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,196,572,708.46</b>	<b>1,191,718,731.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	36,449,908.46	63,567,231.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	36,449,908.46	63,567,231.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,449,908.46	63,567,231.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	1,160,122,800.00	1,128,151,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,160,122,800.00	1,128,151,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>60,026,400.00</b>	<b>98,418,247.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	5,024,247.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,024,247.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	60,026,400.00	93,394,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,026,400.00	93,394,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,291,560,607.18</b>	<b>1,281,474,504.41</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,291,560,607.18</b>	<b>1,281,474,504.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,259,872,939.18</b>	<b>1,258,663,504.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>945,326,328.00</b>	<b>926,020,798.00</b>
210101	Үндсэн цалин	809,175,028.00	817,951,098.00
210104	Урамшуулал	81,697,800.00	53,616,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	54,453,500.00	54,453,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>119,241,073.00</b>	<b>121,750,770.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	80,162,818.00	88,570,534.99
210202	Тэтгэмжийн даатгал	9,545,205.00	8,551,111.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,636,163.00	6,767,786.53
210204	Ажилгүйдлийн даатгал	3,613,352.00	1,695,878.20
210205	Эрүүл мэндийн даатгал	18,283,535.00	16,165,458.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>59,859,800.00</b>	<b>92,394,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,951,140.00	3,891,000.00
210302	Түлш, халаалт	55,908,660.00	88,503,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,367,352.00</b>	<b>14,195,737.00</b>
210401	Бичиг хэрэг	718,600.00	506,987.00
210402	Тээвэр, шатахуун	944,800.00	1,481,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	851,000.00	1,048,400.00
210404	Ном, хэвлэл	522,015.00	333,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,802,500.00	3,627,250.00
210408	Бараа материал акталсны зардал	5,728,437.00	7,198,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,908,641.00</b>	<b>33,317,802.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,500.00	133,100.00
210502	Хоол, хүнс	35,585,781.00	31,327,602.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,306,360.00	1,857,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>1,350,000.00</b>
210604	Урсгал засвар	-	1,350,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>982,600.00</b>	<b>266,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	982,600.00	266,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>830,000.00</b>	<b>1,383,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,000.00	783,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>76,357,145.18</b>	<b>67,984,297.41</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,852,300.00	6,307,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,504,845.18	61,676,347.41
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,687,668.00</b>	<b>22,811,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,002,734.00</b>	<b>19,402,200.00</b>

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,002,734.00	19,402,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,684,934.00	3,408,800.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,684,934.00	3,408,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>(34,961,498.72)</b>	<b>8,662,473.59</b>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>(34,961,498.72)</b>	<b>8,662,473.59</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,906,375.91	595,543,304.34	-436,111,763.50	839,337,916.75
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	679,906,375.91	595,543,304.34	-436,111,763.50	839,337,916.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	679,906,375.91	595,543,304.34	-436,111,763.50	839,337,916.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			8,662,473.59	8,662,473.59
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,906,375.91	595,543,304.34	-427,449,289.91	848,000,390.34

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<b>1,224,149,200.00</b>	<b>1,226,569,747.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>1,160,122,800.00</b>	<b>1,128,151,500.00</b>
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,160,122,800.00	1,128,151,500.00

123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,160,122,800.00	1,128,151,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>64,026,400.00</b>	<b>98,418,247.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,000,000.00	5,024,247.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	5,024,247.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	60,026,400.00	93,394,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,026,400.00	93,394,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,208,079,300.00</b>	<b>1,224,104,747.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,208,079,300.00</b>	<b>1,224,104,747.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,176,422,266.00</b>	<b>1,201,293,747.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	941,391,275.00	930,117,400.00
210101	Үндсэн цалин	805,239,975.00	822,047,700.00
210104	Урамшуулал	81,697,800.00	53,616,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	54,453,500.00	54,453,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	113,693,700.00	125,565,700.00
210201	Тэтгэврийн даатгал	80,006,700.00	81,017,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,421,800.00	16,095,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,737,500.00	7,440,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,684,300.00	1,822,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,843,400.00	19,190,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	63,859,800.00	92,394,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,951,140.00	3,891,000.00
210302	Түлш, халаалт	59,908,660.00	88,503,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,597,335.00	6,999,147.00
210401	Бичиг хэрэг	448,600.00	507,647.00
210402	Тээвэр, шатахуун	944,800.00	1,481,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	851,000.00	1,048,400.00
210404	Ном, хэвлэл	522,015.00	333,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,830,920.00	3,628,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	44,070,676.00	38,804,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	247,500.00	791,600.00
210502	Хоол, хүнс	34,885,166.00	36,154,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,938,010.00	1,858,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	166,600.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	166,600.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	982,600.00	266,700.00
210702	Дотоод албан томилолт	982,600.00	266,700.00

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	830,000.00	1,383,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,000.00	783,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,830,280.00	4,762,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,830,280.00	4,762,800.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,657,034.00</b>	<b>22,811,000.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,972,100.00	19,402,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,972,100.00	19,402,200.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	22,684,934.00	3,408,800.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,684,934.00	3,408,800.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>16,069,900.00</b>	<b>2,465,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>16,069,900.00</b>	<b>2,465,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,069,900.00</b>	<b>2,465,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	16,069,900.00	2,465,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,069,900.00	2,465,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(16,069,900.00)</b>	<b>(2,465,000.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>=</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,221,545,500.00	1,218,136,700.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,221,545,500.00	1,218,136,700.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,198,734,500.00	1,198,734,500.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	930,117,400.00	930,117,400.00
210101	Үндсэн цалин	822,047,700.00	822,047,700.00

210104	Урамшуулал	53,616,200.00	53,616,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	54,453,500.00	54,453,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>125,565,700.00</b>	<b>125,565,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	88,361,200.00	88,361,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,301,100.00	9,301,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,440,900.00	7,440,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,860,200.00	1,860,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,602,300.00	18,602,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,394,000.00</b>	<b>92,394,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,891,000.00	3,891,000.00
210302	Түлш, халаалт	88,503,000.00	88,503,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,524,900.00</b>	<b>6,524,900.00</b>
210401	Бичиг хэрэг	233,400.00	233,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,481,300.00	1,481,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,048,400.00	1,048,400.00
210404	Ном, хэвлэл	333,400.00	333,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,428,400.00	3,428,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>38,554,600.00</b>	<b>38,554,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	541,600.00	541,600.00
210502	Хоол, хүнс	36,154,900.00	36,154,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,858,100.00	1,858,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>266,700.00</b>	<b>266,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	266,700.00	266,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,383,400.00</b>	<b>1,383,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	783,400.00	783,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,927,800.00</b>	<b>2,927,800.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,927,800.00	2,927,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,811,000.00</b>	<b>19,402,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,811,000.00</b>	<b>19,402,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,811,000.00	19,402,200.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,221,545,500.00</b>	<b>1,221,545,500.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,128,151,500.00</b>	<b>1,128,151,500.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,128,151,500.00	1,128,151,500.00

<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		
132001	Орон нутгийн төсвөөс	93,394,000.00	93,394,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	89.00	89.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	51.00	51.00
620003	Үйлчлэх ажилтан	37.00	37.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	443.00	443.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	443.00	443.00
630001	Төрийн өмчит ЕБС	443.00	443.00
630002	Хувийн ЕБС		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>89.0</b>	<b>89.0</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	51.00	51.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26.00	26.00
650010	Гэрээт ажилтан	12.00	12.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5024247.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5024247.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5024247.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	474247.00
Бичиг хэрэг	274,247.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00
<b>Нормативт зардал</b>	250000.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	250000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4300000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,300,000
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	5024247.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5024247.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,024,247.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, өглөгийн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрхэм зорилго нь Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын зөвлөлийн комисс нь байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгаж, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, анги, байгууллагын тодорхойлсон эрсдэлийг нэгтгэн, байгууллагын эрсдэлийн үнэлгээг тогтоож, тайланг аймгийн Боловсролын газарт хүргүүлдэг байна.

Тус сургуульд 2021 онд дотоод аудитын шалгалт ирээгүй бусад эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1291.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 13.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.7 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	7460.5	0.00	-7460.5
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	47564.1	59352.9	11788.8
Үндсэн хөрөнгө	799685.4	788647.5	-11037.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>854710.0</b>	<b>848000.4</b>	<b>-6709.6</b>
Өр төлбөр	15372.0	0.00	-15372.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	839338.0	848000.4	8662.4

<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>854710.0</u></b>	<b><u>848000.4</u></b>	<b><u>6709.6</u></b>
---	------------------------	------------------------	----------------------

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй, авлагын дансны оны эхний 7.5 сая төгрөгийн үлдэгдэлийг барагдуулж оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59.4 сая төгрөг болж 11.8 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 52.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 15.4 сая төгрөгийн бараа материал хүлээн авч үйл ажиллагаандаа 46.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 5.2 сая төгрөгийн материалыг дотоод гүйлгээгээр шилжүүлж, 7.2 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 788.6 сая төгрөг болж 11.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 2.5 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 43.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй, 5.0 сая төгрөгийг хөрөнгийг шилжүүлэн авч, 9.9 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 61.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэнд 15.4 сая төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй ба эцэст бүрэн барагдуулж үлдэгдэлгүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 848.0 сая төгрөг болж 8.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 8.7 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1226.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 2.5 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 10.1 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглахтай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, эд хогшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил зэрэг зардлууд байна.

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглахтай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, эд хогшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлууд өмнөх оноос нэмэгдэж, норматив зардал, томиллолт, зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2021 оны анх батлагдсан төсөв 1248.6 сая төгрөг, тодотгосон төсөв 1221.5 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 27.1 сая төгрөгөөр буурсан байна. Хангамж, бараа материалын зардал 2.6 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 5.0 сая төгрөгөөр нэмж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 1.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 0.1 сая төгрөг, норматив зардлыг 33.6 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 1221.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1218.1 сая төгрөгийг зарцуулж, үдийн цайны зардлын хэмнэлтээс 3.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн 76.4 хувийг цалин, 10.3 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 7.6 хувийг тогтмол зардал, 0.5 хувийг хангамж бараа материалын зардал, 3.2 хувийг норматив зардал, 0.2 хувийг эд хогшил худалдан авах, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 0.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 1.6 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Боловсролын газраас 5.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авчээ. Үүнээс хангамж, бараа материалын зардалд 0.5 сая төгрөг, норматив зардалд 0.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4.3 сая төгрөг, нийт 5.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 1,218.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 1.4 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, Засгийн газрын тогтоолын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1221.5 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1221.5 сая төгрөгийн 119 мэдээллийг ил тод байршуулсан, 18 мэдээллийг хугацаа хоцроож нөхөж байршуулсныг шалгаж үзэхэд мэдээллээ засаж байршуулсантай холбоотой байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш нийт 83.8 сая төгрөгийн 11 гүйлгээ гарсныг бүрэн байршуулсан байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021.11.22-ны 51 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 2.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

#### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

#### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

#### **4.3 Албан шаардлага**

Аудитаар 1.4 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 1,218.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтын дагуу байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж

болох урсгал зардал 14.0 сая төгрөгийн төсвийн 10 хувиар 1.4 сая төгрөгөөр хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-т “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Сургууль нь тайлант онд эмийн зардал, шуудан холбоо, интернэт, бичиг хэрэг, эм, урсгал засварын зардлын тооцоогоор гарсан нийт 2.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 20.2.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж ажиллах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль	2	4.0					1	1.4	1	2.6
<b>Нийт дүн</b>		<b>2</b>	<b>4.0</b>					<b>1</b>	<b>1.4</b>	<b>1</b>	<b>2.6</b>